



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/313

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Монголын уран зургийн галерейн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монголын уран зургийн галерейн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

[Signature]

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Kherreg\Yawsan_Bichig\2017\02\SSA_G18.Docx

УХА0122



МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

УАГ-ын САГ-ын дарга
Ц.Наранчимэг
Утас: 263533

Аудитын менежер:
Я.Самбууням
Утас: 260512

Аудитор: Н.Нямдаваа
Утас: 261885

Монгол Улсын Үндэсний
Аудитын Газар
Засгийн газрын IV байр
Улаанбаатар – 46
Бага тойруу 6
Вэб хуудас: www.audit.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:
“Хүлэгтхүннү Аудит” ХХК

Захирал Е.Оюундэлгэр
Утас: 70140505
Гар утас: 88084464
Цахим хаяг:
info@hulegthunnu.mn

Аудитор Е.Оюундэлгэр
Гар утас: 88084464
Цахим хаяг:
oyundelger@hulegthunnu.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	3
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин.....	3
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа.....	4
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн.....	4
5. Материаллаг байдлын түвшин.....	5
6. Дотоод хяналт.....	5
7. Төсвийн орлого зардлын гүйцэтгэлийн талаар.....	5
8. Шилэн дансны мэдээлэл.....	6
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар.....	6
10. Гол, онцлог гүйлгээний талаар.....	6
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....	6
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар.....	7
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	7
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	8
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
17. Аудитын гэрчилгээний талаар санал дүгнэлт.....	8

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монголын уран зургийн галерейн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/307/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монголын уран зургийн галерейн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Монголын уран зургийн галерейн 2016 оны санхүүгийн тайланд 2016 оны 09 дүгээр сарын 26-наас 2016 оны 10 дугаар сарын 28-ны хооронд завсар үеийн аудит хийсэн бөгөөд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 17-ноос 2017 оны 2 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн “Хүлэгтхүннү Аудит” ХХК-ийн аудитор Е.Оюундэлгэр, аудиторын туслах Б. Ууганбаяр нар гүйцэтгэж хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Монголын уран зургийн галерейн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр “Хүлэгтхүннү аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Хүлэгтхүннү аудит” ХХК аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 17-ноос 2017 оны 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 02 дугаар сарын 22-нд Монголын уран зургийн галерейн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Монголын уран зургийн галерейн төсвийн захирагч нь Монгол Улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Соёлын тухай” “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулиуд болон “Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага”-Монгол Улсын стандарт, Монгол улсын сан хөмрөгийн дүрэм, бусад хууль тогтоомж болон САГ-2017/307/СТА-ТШЗ

БСШУС-ын 2009 оны 98 тоот тушаалаар батлагдсан “Улс, орон нутгийн музейн дүрэм”-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монголын Уран зургийн галерей нь Монголын орчин үеийн дүрслэх урлагийн бүтээлүүдийг олон түмэнд сурталчлан танилцуулах зорилгоор Соёл, урлагийн хөгжлийн хорооны даргын 1991 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 187 тоот тушаалаар Дүрслэх урлагийн музейгээс салж, бие даан үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 1921 оны ардын хувьсгал ялснаас хойш өнөө үе хүртэл бүтээгдсэн дүрслэх урлагийн шилдэг бүтээлүүдийг сонгон цуглуулж, сан хөмрөгөө баяжуулах, судлан сурталчлах, хадгалж хамгаалах, нийгэм, түүх, соёлын хөгжлийн зүй тогтлыг баримтжуулах, дүрслэх урлагаар дамжуулан үзэгчдэд гоо зүйн болон урлагийн боловсрол олгох зорилго, чиглэлтэй төрийн үйлчилгээний байгууллага юм.

Монголын Уран зургийн галерей нь улсын бүртгэлийн 9070004010 тоот, регистрийн 9084789 тоот гэрчилгээтэй, Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, Соёлын төв өргөөний Б корпусыг түрээслэн үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тайлант хугацаанд нийт 15 орон тоотой ажилласан.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн байгууллагын захирагч нь тус байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Монголын Уран зургийн галерейн захирал төсвийн захирагчийн үүрэг гүйцэтгэж, үндсэн үйл ажиллагааны Төрийн сангийн банк дахь 900035016 тоот, нэмэлт санхүүжилтийн 900035411 тоот дансны баримтанд нэгдүгээр гарын үсгийг захирал Н.Батбаатар, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Э.Батбаатар нар зурж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна. Аудитын ажлын явцад захирал Н.Батбаатар нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн Б/03 тоот тушаалаар үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөж, захирлын ажлын чиг үүргийг менежер Э.Баатарсүх түр орлон гүйцэтгэж байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монголын уран зургийн галерейн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Монголын уран зургийн галерейн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй

нотолгоо олж авахын тулд байгууллагын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 12 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Aсoulos 3.0 санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлын түвшин:

Монголын уран зургийн галерейн санхүүгийн тайлан дахь материаллаг байдлын суурийг төлөвлөлтийн үе шатанд нийт орлогоос тооцоход улсын төсөвт төвлөрүүлдэг буюу байгууллагын үйл ажиллагаанд зарцуулдаггүй орлого нэмэгдэж тооцогдоно, нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн өндөр байгаа тул 385.3 сая төгрөгийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгон авч, 1 хувиар тооцон 3.9 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн үеийн материаллаг байдлын түвшинг хэвээр нь авах нь зүйтэй гэж үзлээ.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монголын уран зургийн галерей нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд байгууллагын менежер дотоод хяналтыг хэрэгжүүлдэг. Төлөвлөлтийн үед дотоод хяналтын эрсдлийг бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлж, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Монголын уран зургийн галерейн төсвийн захирагч нь 2016 онд 297.6 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал санхүүжилтийн 260.2 сая, нэмэлт санхүүжилтийн 35.5 сая, нийт 295.7 сая төгрөгийн санхүүжилт авч, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 40.5 сая төгрөг, бараа үйлчилгээний орлого 27.7 сая төгрөг, нийт 363.9 сая төгрөгийн орлого олж, орлогын төлөвлөгөөг 28.2 сая төгрөгөөр

буюу 9,4 хувиар илүү биелүүлжээ. Үүнээс урсгал зардалд 297.6 сая төгрөг батлагдсанаас 271.8 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 25.8 сая төгрөгөөр буюу 8,7 хувиар хэмнэсэн бөгөөд хэмнэлтэнд цалингийн зардал (23,2 хувь), бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлууд (68,2 хувь) гол нөлөө үзүүлсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Монголын уран зургийн галерей нь Монгол Улсын “Шилэн дансны тухай” хуулийн дагуу 2016 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбар, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, 2017 оны төсвийн төсөл, зэрэг мэдээллийг өөрийн сайт болон www.shilendans.gov.mn/ цахим хуудсанд байршуулж, төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажилласан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 12 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 18 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Эдгээр нарийвчилсан горим сорил нь нийт кассын гүйлгээний 100 хувь, харилцахын гүйлгээний 14,2 хувь, бараа материалын 69,5 хувь, нийт хөрөнгийн 100 хувь, нийт зардлын 6,8 хувийг тус тус хамарч байна. Үр дагаврыг тодорхойлбол, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, 14.7 сая төгрөгийн авлага барагдуулах талаар өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж шүүхэд хүсэлт гаргасан хэдий ч тухайн асуудлыг шүүх хараахан шийдвэрлээгүй байгаа, элэгдлээрээ өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг данснаас хасаагүй байгаа зэрэг зөрчлүүд нь үнэн зөв байх, иж бүрэн байх, хэмжилт, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаар:

Монголын уран зургийн галерейн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, үндсэн хөрөнгө, өөрийн үйл ажиллагааны орлого, борлуулсан бүтээгдэхүүний өртөг, удирдлагын зардал, санхүүгийн тайлан зэрэгт ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тайлант хугацаанд Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2016 оны 05 сарын 30-ны өдрийн А/227 тоот тушаалын дагуу улсын санд 40.5 сая төгрөгийн өртөгтэй дүрслэх урлагийн 5 шилдэг бүтээлийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан.

Уран зургийн галерейн захирлын 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/12 тоот тушаалаар батлагдсан байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлын шийдвэрээр хугацаа хэтэрч ашиглах боломжгүй болсон 21.1 сая төгрөгийн материалыг акталсан байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг зөрчил илрээгүй бөгөөд материаллаг бус хэмжээний дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллаагүй нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 17.2-т “байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, журам, зааварт нийцүүлэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан баталж, мөрдөж ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх

2. Захирал Н.Батбаатарт олгосон цалингийн урьдчилгааг татвар тооцоогүй цалингаас суутгаснаас шалтгаалан 0,4 сая төгрөгөөр дутуу суутгасан нь ХХОАТ-ын тухай хуулийн 8.1.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод албан татвар ногдуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтнуудын цалингаас холбогдох суутгалуудыг хуулийн дагуу зөв тооцон суутгаж, зөрчлийг дахин гаргахгүй байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх

3. Ажилтнуудын хоол, унааны мөнгөнөөс ХХОАТ суутгахдаа ЭМНДШ-ийг хасч тооцсон учраас 0,3 сая төгрөгийн татварын өр үүссэн нь ХХОАТ-ын тухай хуулийн 22.1.4-т “Шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр”, “Төсвийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтнуудын хоол, унааны мөнгө буюу шууд бус орлогоос холбогдох суутгалуудыг хуулийн дагуу зөв тооцон суутгаж, зөрчлийг дахин гаргахгүй байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх

4. Өмнөх аудитын өгсөн зөвлөмжийн дагуу 14.7 сая төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулахын тулд шүүхэд хүсэлт гаргасан боловч хараахан шийдвэрлэгдээгүй байгаа нь “Төсвийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуримтлагдсан авлагыг түргэн шуурхай барагдуулахын тулд хуулийн байгууллага болон холбогдох яамдад тухайн асуудлаар өгсөн нэхэмжлэл, хүсэлтийг шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх

5. Элэгдлээрээ өртгөө нөхсөн 124,54 сая төгрөгийн анхны өртөгтэй, 109 нэр төрлийн үндсэн хөрөнгө байгаа нь НББОУС-16.34-т “...хөрөнгийн бодит үнэ цэнэ нь түүний дансны үнээс ихээхэн ялгаатай бол дахин үнэлгээг зайлшгүй хийнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эдгээр хөрөнгүүдийг цаашид хэрхэн ашиглах талаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн арга хэмжээ авч ажиллах.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад материаллаг зөрчил илрээгүй бөгөөд материаллаг бус 0.4 сая төгрөгийн зөрчлийг асуудлын бүртгэлд тусгаж, аудитын зөвлөмж өгсөн болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Монголын уран зургийн галерейн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Монголын уран зургийн галерейн 2016 оны санхүүгийн тайланд аудитаар нийт 0.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс санхүүгийн тайланд залруулга хийгээгүй бөгөөд зөрчлийг дахин гаргахгүй байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгсөн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

2015 онд санхүүгийн тайлангийн аудитаар 3 асуудлаар зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн биелэлтийг ирүүлсэн бөгөөд хэрэгжилт 66,6 хувьтай байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монголын уран зургийн галерейн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

Бэлтгэсэн:

Аудитор

Е.Оюундэлгэр

Чанарын хяналтын аудитор

Ё.Наранбилэг

Хянасан:

Аудитын менежер

Я.Самбууням

Санхүүгийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор

Ц.Наранчимэг

**МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙН
ЗАХИРЛЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Э.БААТАРСҮХ ТАНАА**

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Монголын уран зургийн галерейн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Монголын уран зургийн галерейн удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй Аудитын олон улсын стандартын Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

“Хүлэгтхүннү Аудит” ХХК нь Монголын уран зургийн галерейн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

“Хүлэгтхүннү Аудит” ХХК аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголын уран зургийн галерейн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монголын уран зургийн галерейн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАГНАЛЫН
ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХЯНАЛТЫН ХУУДАС**

Аудитын нэр: Монголын уран зургийн галерейн 2016 оны санхүүгийн тайлан

Аудитын код: САГ-2017/307/СТА-ТШЗ

Аудитын багийн нэр: “Хүлэгтхүннү аудит” ХХК-ийн

Аудитор Е.Оюундэлгэр

Туслах аудитор Б.Ууганбаяр

Тайлант жил: 2016 он

№	Аудитыг тайлагнах шатанд бүрдүүлэх баримтын нэр	Хяналт хийсэн огноо		Тайлбар
		Анхан шатны хяналт	Хоёрдах шатны хяналт	
1	Аудитын тайлан	✓	✓	
2	Ерөнхий аудиторроор гарын үсэг зуруулахаар бэлтгэсэн Аудитын гэрчилгээ	✓	✓	
3	Менежментийн захидал	✓	✓	
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	✓	✓	
5	Санхүүгийн тайланд аудит хийлгэх тухай байгууллагын албан бичиг болон санхүүгийн тайлан	✓	✓	
5	Акт, албан шаардлагын төсөл			Байхгүй
6	Хянан удирдах ажилтнуудын үүргийн хэрэгжилт			Байхгүй

Бэлтгэсэн: Аудитор

Е.Оюундэлгэр

Анхан шатны хяналт хийсэн:
Аудитын менежер :

Я.Самбууням

Хоёрдах шатны хяналт хийсэн:
САГ-ын дарга, тэргүүлэх аудитор:

Ц.Наранчимэг

Аудитын менежерийн санал:

Тэргүүлэх аудиторовын санал:

**МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЭЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын

баримт бичгийн талаар 3

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1

Авлага, өр төлбөрийн талаар 3

Асуудал 2

Үндсэн хөрөнгийн талаар 4

2010 оны 3 дугаар сарын 01

2017 оны 02 дугаар сарын 16

Менежментийн захидал

Аудитын ажил гүйцэтгэх гэрээгээр “Хүлэгтхүннү аудит” ХХК-ийн илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Монголын уран зургийн галерейн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Бидний энэхүү зөвлөмж та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан нийт ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил, түүний хэрэгжилтийн талаарх хариуг 2017 оны 06 дугаар сарын 30-ны дотор Үндэсний Аудитын Газарт ирүүлнэ үү.

Асуудал 1: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

Аудиторын ажиглалт

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллаагүй нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 17.2-т “байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, журам, зааварт нийцүүлэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

Аудиторын зөвлөмж

“Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулинд заасны дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангууд буруу илэрхийлэгдэх, УСНББОУС, НББОУС-тай нийцэхгүй байх /ЭҮ, ТИ, ҮЗ/

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 1: Авлага, өр төлбөрийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---	----------------------------------

Аудиторын ажиглалт

1. Захирал Н.Батбаатарт олгосон цалингийн урьдчилгааг татвар тооцоогүй цалингаас суутгаснаас шалтгаалан 0,4 сая төгрөгөөр дутуу суутгасан нь ХХОАТ-ын тухай хуулийн 8.1.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод хувь хүний орлогын албан татвар ногдуулна” гэж заасантай нийцэхгүй байна.
2. Ажилтнуудын хоол, унааны мөнгөнөөс ХХОАТ суутгахдаа ЭМНДШ-ийг хасч тооцсон учраас 0,3 сая төгрөгийн татварын өр үүссэн нь ХХОАТ-ын тухай хуулийн 22.1.4-т “Шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр”, “Төсвийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Аудиторын зөвлөмж

Ажилтнуудын цалингаас холбогдох суутгалуудыг хуулийн дагуу зөв тооцон суутгаж, зөрчлийг дахин гаргахгүй байх.

Ажилтнуудын хоол, унааны мөнгө буюу шууд бус орлогоос холбогдох суутгалуудыг хуулийн дагуу зөв тооцон суутгаж, зөрчлийг дахин гаргахгүй байх.

3. Өмнөх аудитын өгсөн зөвлөмжийн дагуу 14.7 сая төгрөгийн авлагыг барагдуулахын тулд шүүхэд хүсэлт гаргасан боловч хараахан шийдвэрлэгдээгүй байгаа нь “Төсвийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Хуримтлагдсан авлагыг түргэн шуурхай барагдуулахын тулд хуулийн байгууллага болон холбогдох яамдад тухайн асуудлаар өгсөн нэхэмжлэл, хүсэлтийг яаралтай шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах.

Эрсдэлүүд

Орлого, зарлагын гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх /ЭҮ, ИБ, ҮЗ/

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

Аудиторын ажиглалт

Элэгдлээрээ өртгөө нөхсөн 124,54 сая төгрөгийн анхны өртөгтэй, 109 нэр төрлийн үндсэн хөрөнгө байгаа нь НББОУС-16.34-т “...хөрөнгийн бодит үнэ цэнэ нь түүний дансны үнээс ихээхэн ялгаатай бол дахин үнэлгээг зайлшгүй хийнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудиторын зөвлөмж

Эдгээр хөрөнгүүдийг цаашид хэрхэн ашиглах талаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн арга хэмжээ авч ажиллах.

Эрсдэлүүд

Санхүүгийн байдлын тайлан дахь үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл бодит үнэ цэнээс өөрөөр тайлагнагдах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх. /Ү, Х, ТИ, ҮЗ/

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙ
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	2,400.00	0.00
Кассад байгаа бэлэн мөнгө	2,400.00	0.00
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/		0.00
АВЛАГА	14,661,154.69	14,661,154.69
Бусад авлага	14,661,154.69	14,661,154.69
БАРАА МАТЕРИАЛ	119,778,198.50	94,098,949.50
Хангамжийн материал	118,277,217.00	92,715,760.00
Бусад	1,500,981.50	1,383,189.50
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	134,441,753.19	108,760,104.19
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,216,526,251.29	15,223,699,111.69
Биет хөрөнгө	15,216,465,140.94	15,223,699,111.69
Авто тээврийн хэрэгсэл	18,057,500.00	18,057,500.00
Хуримтлагдсан элэгдэл		(1,805,750.04)
Машин тоног төхөөрөмж	104,572,135.93	104,572,135.93
Хуримтлагдсан элэгдэл	(71,077,626.41)	(94,272,096.24)
Тавилга эд хогшил	79,187,393.41	79,187,393.41
Хуримтлагдсан элэгдэл	(49,108,143.99)	(57,373,953.37)
Номын фонд	1,228,182.00	1,228,182.00
Түүх соёлын дурсгалт зүйлс	15,133,605,700.00	15,174,105,700.00
Биет бус хөрөнгө	61,110.35	0.00
Программ хангамж	1,370,000.00	1,370,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(1,308,889.65)	(1,370,000.00)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,216,526,251.29	15,223,699,111.69
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	15,350,968,004.48	15,332,459,215.88
Богино хугацаат өр төлбөр		273,975.30
Өглөг		273,975.30
Ажиллагчидтай холбоотой өглөг		273,975.30
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		273,975.30
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		273,975.30
Засгийн газрын оруулсан капитал	859,650,551.83	859,650,551.83
Өмнөх үеийн үр дүн	176,593,216.65	176,593,216.65
Тайлант үеийн үр дүн		(18,782,763.90)
Дахин үнэлгээний зөрүү	14,314,724,236.00	14,314,724,236.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,350,968,004.48	15,332,185,240.58
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,350,968,004.48	15,332,459,215.88

МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙ
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
Улсын төсвөөс	292,730,773.70	295,696,064.00
Урсгал	272,214,600.00	260,216,700.00
Улсын төсвөөс-Нэмэлт санхүүжилт	20,516,173.70	35,479,364.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс		25,200,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	20,516,173.70	10,279,364.00
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	76,309,763.87	68,208,650.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого		23,432,640.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	37,674,360.80	68,208,650.00
Төсвийн урамшуулал	3,821,719.66	
Үндсэн үйл ажиллагааны орлого		4,276,010.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	34,813,683.41	40,500,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	369,040,537.57	363,904,714.00
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	300,124,045.72	356,315,622.59
АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	105,929,310.72	121,294,334.32
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	95,257,236.00	109,392,776.30
Цалин	89,737,236.00	109,392,776.30
Цалингийн тусгай нэмэгдлүүд	5,520,000.00	-
Нийгмийн хамгааллын шимтгэл	10,672,074.72	11,901,558.02
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	10,672,074.72	11,901,558.02
Тэтгэвэрийн даатгалын шимтгэл		
Бусад бараа ажил үйлчилгээний зардал	194,194,735.00	235,021,288.27
Бичиг хэргийн материал	1,693,500.00	1,138,880.00
Шуудан холбоо интернетийн төлбөр	1,318,725.04	1,966,259.67
Дотоод томилолтын зардал	525,000.00	504,600.00
Ном, хэвлэлийн зардал	69,600.00	94,692.00
Жижиг эд хогшил худалдан авах зардал	444,425.00	
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс		26,808,717.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	384,000.00
Төлбөр хураамж, бусад татварын зардал	18,327,770.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр		21,450,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил		20,450,000.00
Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал		1,000,000.00
Урсгал засварын зардал	5,750,000.00	2,057,000.00
Байрны түрээсийн зардал	150,000,000.00	127,500,000.00
Элэгдлийн зардал	11,693,996.00	33,327,139.60
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,930,000.00	
Бусад	1,241,719.00	19,790,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,368,649.40	26,371,855.31
Бусад урсгал шилжүүлэг		
Төвлөрүүлэх шилжүүлэг	44,368,649.40	26,371,855.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	344,492,695.16	382,687,477.90
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	24,547,842.41	(18,782,763.90)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	24,547,842.41	(18,782,763.90)

МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙ
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	292,730,773.70	298,853,168.00
Улсын төсвөөс	292,730,773.70	260,216,700.00
Урсгал	272,214,600.00	260,216,700.00
Бусад төсөвт байгууллагаас		1,903,401.00
Нийгмийн даатгалын сангаас		1,253,703.00
Улсын төсвөөс Нэмэлт санхүүжилт	20,516,173.70	35,479,364.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан		25,200,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан		10,279,364.00
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	334,226,854.16	27,708,650.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	37,674,360.80	27,708,650.00
Үндсэн үйл ажиллагааны орлого		4,276,010.00
Төсвийн урамшуулал	3,821,719.66	
Үндсэн бус үйл ажиллагааны орлого		23,432,640.00
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого		
Бусад орлого		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	334,226,854.16	326,561,818.00
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	300,192,362.69
Ажиллагчидтай холбогдсон зардал	-	122,274,062.02
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	96,437,236.00	110,372,504.00
Цалин	90,917,236.00	101,146,904.00
Унаа хоолны хөнгөлөлт	5,520,000.00	9,225,600.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,672,074.72	11,901,558.02
Тэтгэврийн даатгалын шимтгэл	10,672,074.72	11,901,558.02
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	226,855,143.44	177,918,300.67
Бичиг хэргийн материал	1,693,500.00	937,840.00
Шуудан холбооны зардал	1,318,725.04	1,966,259.67
Дотоод албан томилолт	525,000.00	504,600.00
Ном, хэвлэлийн зардал	69,600.00	0.00
Жижиг эд хогшил худалдан авах зардал	430,180.00	0.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	200,000.00	384,000.00
Төлбөр хураамж, бусад татварын зардал	18,327,770.00	0.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,425,200.00
Урсгал засварын	5,750,000.00	2,057,000.00
Байрны түрээс	150,000,000.00	127,500,000.00
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,930,000.00	
Бусад зардал	1,241,719.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр		21,450,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний		20,450,000.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,000,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		21,693,401.00
Бараа үйлчилгээний бусад зардал		21,693,401.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		26,371,855.31
Бусад урсгал шилжүүлэг	44,368,649.40	26,371,855.31
Төвлөрүүлэх шилжүүлэг	44,368,649.40	26,371,855.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	333,964,454.16	326,564,218.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	262,400.00	(2,400.00)
Хөрөнгийн орлого	-	-

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	260,000.00	
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	260,000.00	0.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(260,000.00)	0.00
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
Засгийн газрын бондын үндсэн төлбөр		
Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөр		-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,400.00	(2,400.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,400.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,400.00	-

МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙ
АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙНТАЙЛАН
2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2015 оын 1-сарын 1-ээрх үлдэгдэл	0.00	0.00		0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00		
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлангийн үеийн үр дүн				0.00
2015 оын 12 сарын 31-ээрх үлдэгдэл	859,650,551.83	14,314,724,236.00	176,593,216.65	15,350,968,004.48
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	859,650,551.83	14,314,724,236.00	176,593,216.65	15,350,968,004.48
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлангийн үеийн үр үн			(18,782,763.90)	(18,782,763.90)
2016 оын 12 сарын 31-ээрх үлдэгдэл	859,650,551.83	14,314,724,236.00	157,810,452.75	15,332,185,240.58

МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙ
ТОХИРУУЛГА ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	297,589,400.00	271,835,258.69	25,754,141.31	91.3
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	297,589,400.00	271,835,258.69	25,754,141.31	91.3
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	297,589,400.00	271,835,258.69	25,754,141.31	91.3
1. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	297,589,400.00	271,835,258.69	25,754,141.31	91.3
1.1 Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	111,197,800.00	105,154,301.00	6,043,499.00	94.6
Үндсэн цалин	101,972,200.00	95,928,701.00	6,043,499.00	94.1
Унаа болон бусад нөхөн олговор	9,225,600.00	9,225,600.00	0.00	100.0
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,231,800.00	11,466,058.02	765,741.98	93.7
Тэтгэврийн даатгал	12,231,800.00	11,466,058.02	765,741.98	93.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,500,000.00	127,500,000.00	0.00	100.0
Байрны түрээс	127,500,000.00	127,500,000.00	0.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	3,318,700.00	3,319,299.67	(599.67)	100.0
Бичиг хэргийн материал	635,600.00	437,840.00	197,760.00	68.9
Шуудан холбооны зардал	1,204,800.00	1,456,259.67	(251,459.67)	120.9
Бага үнэтэй түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,478,300.00	1,425,200.00	53,100.00	96.4
Нормативт зардал	422,200.00	384,000.00	38,200.00	91.0
Зөөлөн эдлэл, нормын хувцас	422,200.00	384,000.00	38,200.00	91.0
Эд хогшил худалдан авах	3,366,600.00	2,057,000.00	1,309,600.00	61.1
Урсгал засвар	3,366,600.00	2,057,000.00	1,309,600.00	61.1
Томилолт, зочны зардал	504,600.00	504,600.00	0.00	100.0
Дотоод албан томилолт	504,600.00	504,600.00	0.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	39,047,700.00	21,450,000.00	17,597,700.00	54.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,047,700.00	20,450,000.00	17,597,700.00	53.7
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
ТАТААС			0.00	
Бусад урсгал шилжүүлэг			0.00	
Төвлөрүүлэх шилжүүлэг			0.00	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	297,589,400.00	271,832,858.69	25,756,541.31	91.3
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	10,000,000.00	23,432,640.00	(13,432,640.00)	234.3
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,775,000.00	4,276,010.00	5,498,990.00	43.7
Төсвөөс санхүүжих	277,814,400.00	244,124,208.69	33,690,191.31	87.9
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		2,400.00	(2,400.00)	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	0.00	
БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЧДЫН ТОО				
АЖИЛЛАГСАД БҮГД	15	15	0	100.0
Удирдах ажилтан	1	1	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	7	7	0	100.0
Үйлчлэх ажилтан	7	7	0	100.0
СУРАЛЦАГСАД /жилийн дунджаар/				
Ерөнхий боловсролын сургуульд суралцагсад		0	0	

МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙ
НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	25,200,000.00
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	0.00	25,200,000.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	0.00	25,200,000.00
1. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	25,200,000.00
1.1 Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	3,964,500.00
Үндсэн цалин		3,964,500.00
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		435,500.00
Тэтгэврийн даатгал		435,500.00
Хангамж, бараа материалын зардал	-	1,010,000.00
Бичиг хэрэг		500,000.00
Шуудан холбоо		510,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		19,790,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		19,790,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	25,200,000.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	25,200,000.00
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЧДЫН ТОО		
АЖИЛЛАГСАД БҮГД	15	15
Удирдах ажилтан	1	1
Гүйцэтгэх ажилтан	7	7
Үйлчлэх ажилтан	7	7
СУРАЛЦАГСАД /жилийн дунджаар/		
Ерөнхий боловсролын сургуульд суралцагсад		0